

Харилцах

Монгол Улсад



Др. Алфред Катер

Төслийн удирдагч
ИАК Аграр Консалтинг ХХК
Хаяг: Засгийн газрын IXа байр,
501, Энхтайвны өргөн чөлөө 16а
13381 Улаанбаатар
Утас: +976 95520608
И-мэйл: a.kather@iakleipzig.de
Вэб: www.iakleipzig.de

Герман Улсад



Мари Кюнстинг

Төслийн зохицуулагч
ИАК Аграр Консалтинг ХХК
Хаяг: Борнаер гудамж 16
04288 Лайпциг
Утас: +49 34297 71419
Факс: +49 34297 42809
И-мэйл: m.kuenstling@iakleipzig.de
Вэб: www.iakleipzig.de



Эрхлэн гаргасан

Эрхлэн гаргасан

Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яам (ХХХААЯ)
Вилхельм гудамж 54
Реферат 624
10117 Берлин

ГФА Консалтинг Групп ХХК
Валл гудамж 15
10179 Берлин

Хэвлэсэн огноо

2016 оны 6 сар

Текст

ИАК Аграр Консалтинг ХХК

Эх бэлтгэл

design.ideo, büro_für_gestaltung, Erfurt

Гэрэл зураг

ИАК Аграр Консалтинг ХХК

Хэвлэл

ХХХААЯ

Энэхүү төсөл нь (төслийн дугаар: MNG 16-01) Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яамны санхүүжилтээр ГФА Консалтинг Групп ХХК-аар дамжуулан хэрэгжиж байна.



Дэлгэрэнгүй мэдээллийг доорхи хаягнаас авна уу
www.bmel-kooperationsprogramm.de



Холбооны
Хүнс,
хөдөө аж ахуйн яам



Монгол Улс дахь Тогтвортой хөдөө аж ахуй

ХБНГУ, Монгол Улсын хамтын ажиллагааны төсөл



Төслийн тухай

Хөдөө аж ахуй нь Монгол улсын эдийн засгийн уламжлалт салбар билээ. Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө тогтмол өсч байгаа хэдий ч хөдөө аж ахуйн салбар нь 2015 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 16,6 орчим хувийг үйлдвэрлэж, цаашдаа ч өргөжиж, бүтээгдэхүүнээ экспортолох боломж ихтэй салбар хэвээр байна.

УИХ-аас 2016 оны 1-р сард баталсан Тариалангийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газраас баталсан Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар 2016-2025 оны хооронд баримтлах бодлогын баримт бичиг нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын ирээдүйн хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулжээ. Эдгээр баримт бичигт нэн тэргүүнд экологийн хувьд тогтвортой, эдийн засгийн үр ашигтай тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах мөн экспортыг нэмэгдүүлэх зэрэг зорилгуудыг дэвшүүлжээ.

Герман-Монголын хамтын ажиллагааны Тогтвортой хөдөө аж ахуй төсөл нь Монгол Улсын Засгийн Газрыг дээрхи хөгжлийн зорилгуудад хүрэхэд дэмжиж ажиллах бөгөөд хоёр орны хөдөө аж ахуйн салбарын мэргэжлийн яриа хэлэлцээг эрчимжүүлэхийг зорих юм.



Төслийн зорилго ба хамрах хүрээ



Хөдөө аж ахуйн бодлого, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн түвшинд харилцан туршлага солилцож, мэдлэг дамжуулах замаар Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын шинэчлэлийг дэмжиж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Төсөл нь түнш байгууллагуудын хэрэгцээнд тулгуурлан, хөдөө аж ахуйн холбогдох сэдвүүдээр зөвлөх үйлчилгээ, сургалтууд зохион байгуулж, судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэх ба үйл ажиллагаа нь хөрс хамгаалал, үр сортын эрхзүйн орчныг сайжруулах мөн газар тариалангийн салбарын эрсдлийн менежмент, даатгалын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэгдэнэ.

Төслийн үйл ажиллагаа

- Тогтвортой, дэвшилтэт хөдөө аж ахуйн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд салбарын бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад зөвлөгөө өгөх;
- Төсөл нь хамтрагч талууд болон зорилтот бүлгүүдийг мэргэжлийн чухал мэдээ, мэдээллээр хангах;
- Сонгосон сэдвүүдээр хурал, зөвлөгөөн, уулзалт ярилцлага зэрэг үйл ажиллагаа зохион байгуулах;
- Хөдөө аж ахуйн салбарын удирдах болон мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжил дээшлүүлэх болон давтан сургалтууд зохион байгуулах.

Хамтрагч талууд

Энэхүү хамтарсан төслийг дэмжигч нь Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яам, Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам юм.

Төслийг ИАК Аграр Консалтинг ХХК-ийн удирдлагаар АФС Консултантс Интернейшнл ХХК, Дойла Нийнбург ХХК, ДЛЖ-Интернэйшнл ХХК зэрэг байгууллагууд хамтран хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн болно.

Герман-Монголын хамтын ажиллагааны Тогтвортой хөдөө аж ахуй төсөл нь Хөдөө аж ахуйн их сургуультай газар тариалангийн үйлдвэрлэлд шинэлэг, дэвшилтэт шийдлүүдийг нэвтрүүлэх тал дээр хамтран ажиллаж байна. Мөн ХААИС-ийн харьяа Дархан-Уул аймаг дахь Ургамал, газар тариалангийн хүрээлэн нь практикт тулгуурласан судалгаа шинжилгээ талаас ялангуяа сорт сорилт, үр үржүүлгийн чиглэлээр төслийн бас нэгэн чухал хамтрагч юм.

Түүнчлэн төсөл нь мэргэжлийн холбоод, ТББ-уудтай нягт хамтран ажиллах бөгөөд эдгээр байгууллагууд нь тариаланчдыг холбож, мультипликаторын үүрэг гүйцэтгэж байна.

